



ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 10 сарын 21 өдөр

Дугаар 24

Улаанбаатар хот

Компанийн зохион байгуулалтын орон тооны дээд хязгаарыг шинэчлэн тогтоох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.3.3 дахь заалт, Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 61 дүгээр тогтоол, “Эрчист Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн удирдамж, чиглэл өгөх тухай 31 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн орон тооны дээд хязгаарыг үндсэн ажилтан 36, гэрээт ажилтан 41, нийт 77 байхаар шинэчлэн тогтоосугай.
2. Компанийн орон тооны дээд хязгаарыг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан зохион байгуулалтын бүтцийг хавсралтаар шинэчлэн баталсугай.
3. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 13 дугаар тогтоолын 3 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 10 дугаар тогтоолын хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.
4. Батлагдсан орон тооны хязгаарт багтаан ажлын байрны тодорхойлолт, албан тушаалын нэр, орон тооны жагсаалтыг шинэчлэн батлахыг Төрийн өмчийн төлөөлөгч бөгөөд Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч (А.Молор)-т зөвшөөрсүгэй.
5. Компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарт багтаан үйл ажиллагаа явуулахыг Төрийн өмчийн төлөөлөгч бөгөөд Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч (А.Молор)-т үүрэг болгосугай.
6. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо (Л.Амгалан)-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ц.ТҮВШИНЗАЯА



"Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл 2026 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 24 дүгээр тогтоолын хавсралт

"ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИ" ТӨХХК ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ

